

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,  
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2016 оны 03 дугаар  
сарын 23 -ны .... өдөр

Дугаар А/173, а/114

Улаанбаатар хот

Агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, бүсэд мөрдөх  
журам тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААЖ, ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын Агаарын чанарыг сайжруулах бүсийг нэгдүгээр, Бүсэд мөрдөх журамыг хоёрдугаар, хилийн зааг байршлыг харуулсан 1:25000-аас доошгүй масштаб бүхий газрын зургийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Арвайхээр сумын "Агаарын чанарыг сайжруулах бүсийн хилийн зааг" тогтоосон талаар олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Хэвлэл, мэдээллийн алба / Г.Ганхуяг/, Арвайхээр сумын Засаг дарга /А.Ишдорж/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал, захирамжийг хэрэгжүүлж хяналт тавьж, ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Цэнгэл/, Өвөрхангай аймгийн засаг даргын орлогч /О.Батжаргал/-д тус тус даалгасугай.

БАТЛАВ:  
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН  
ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД



Н.БАТЦЭРЭГ

БАТЛАВ:  
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА



Д.ТОГТОХСҮРЭН